

Увс аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Юнэрэн овогтой Төгсжаргал -ийн мөрийн хөтөлбөр

### **МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ НЬ:**

Увс аймгийнхаа нийгэм эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлж, төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргах, иргэдийнхээ аж амьдралыг дээшлүүлэхэд чиглэгдэх болно.

### **НЭГ. ХҮН АМЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ, АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ**

Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын үйлчилгээгээр дамжуулан айл өрхийн амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

- 1.1 Сумын хүн амын амьжиргааны төвшингийн судалгааг шинэчлэн гаргаж ядуурлын шалтгаанд дүгнэлт хийн, ядуурлыг бууруулах, арилгахад чиглэсэн, бодлогыг авч хэрэгжүүлнэ.
- 1.2 Ажилгүйдэл ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд ажил идэвхтэй ирж буй иргэдийн судалгааг гаргаж 60-аас доошгүй иргэний мэргэжлийн сургалтад хамруулахад анхаарч олон нийтийг хамарсан ажилд татан оролцуулах, боломжийг бий болгоно.
- 1.3 Нийгмийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай гэр оронгүй өрх, иргэдийг тодорхой журмын дагуу "Гэр" хөтөлбөрт хамруулна.
- 1.4 Сумынхаа нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй эмзэг бүлгийн өрхүүдийн түлээ, нүүрсний үнэнд тодорхой хөнгөлөлтийг олгодог журмыг хэрэгжүүлж хяналт тавин ажиллана.
- 1.5 Сумын хэмжээнд "Ахмадын сан" байгуулж уг сангийн үйл ажиллагааг ахмадуудад төрөл бүрийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулж хамтран ажиллана.

### **ХОЁР. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**

Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлэн сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлэхийн тулд багш нарын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдүүлэн тэдний мэдлэг чадвар үлгэр дуурайлыг нэмэгдүүлж хүүхдэд ээлтэй ая тухтай сургалт хүмүүжлийн орчинг бүрдүүлнэ.

- 2.1 Сумын нутаг дэвсгэр дээр ирэх онуудын улсын нэгдсэн төсөвт цэцэрлэг барих хөрөнгө суулгах талаар төлөвлөгөө боловсруулан аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлнэ.
- 2.2 Математик болон байгалийн ухааны чиглэлээр хот аймаг, бүсийн улсын олимпиадад амжилт гаргасан багийнхаа авъялаг сурагчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх журмыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж ажиллана.
- 2.3 Сургууль цэцэрлэгийн сургалтын орчныг сайжруулах зорилгоор төсвийн болон олон улсын төсөл хөтөлбөрүүдийн эх үүсвэрийг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмж, тоглоом наадгайн хангалтыг нэмэгдүүлэх талаар санаачлан ажиллана.
- 2.4 Үдийн хоол хөтөлбөрийг цаг тухайд нь чанартай хэрэгжүүлж байгаад хяналт тавина.

2.5 Сумынхаа мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг ажлын байраар хангахад анхаарна.

2.6 Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх, соёлын үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах, ард түмний оюуны өв сан, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, сэргээн засварлах, ардын уламжлалт урлаг, зан үйлийг сурталчилна өвлүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.

2.7 Соёл урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж орон нутгийн болон улсын чанартай уралдаан тэмцээнийг уламжлал болгохоос гадна багийн дуучид уран бүтээлчид урлаг спортод амжилт гаргасан, идэвхтэй оролцогчдын алдарыг тэмдэглэх, тэднийг алдаршуулах ажлыг зохион байгуулах

2.8 Аймгийн төв номын санг цахим мэдээллийн сүлжээнд холбож сумын номын сангийн фондыг жил бүр баяжуулж, уншигчдын тоог нэмэгдүүлнэ.

2.9 Орон нутгийн соёл урлагийн байгууллагын ажиллах орчин нөхцөлийг стандарт нийцүүлэн сайжруулах, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд хөрөнгийн асуудлаар төсөл боловсруулж, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж шийдвэрлүүлэх

### **ГУРАВ. ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой тогтолцоог бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагуудын материаллага баазыг бэхжүүлж үйл ажиллагааны чадамжийг дээшлүүлнэ.

3.1 Эмнэлэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан эх нялхсын эндэгдлийг улсын дундаж түвшингээс бууруулахад чиглэсэн зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч ажиллана.

3.2 Эрүүл мэндийн салбарын эм хангамж, хүний нөөцийн талаар орон нутгийн онцлогт тохирсон бодлого хэрэгжүүлж ажиллана.

3.3 Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой эмзэг бүлгийн хүн амыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношлогоонд үнэ төлбөргүй хамруулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авах саналыг аймгийн ИТХ-д оруулна.

3.4 Сумынхаа хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн эмчийн унаа, хөдөлмөр хамгаалалтын хувцас, эм хангамжийн багаж хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

3.5 Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, спортын материаллаг баазыг бэхжүүлэх ажлыг бүх талаар дэмжиж ажиллана.

### **ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ**

Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн уян хатан зохицож чаддаг, идэвхтэй, санаачлагатай, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлнэ.

4.1 Төрийн бүх шатны байгууллага төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөрлүүлж хууль тогтоомжийг гажуудуулсан хөшүүн хойрго хандсан аливаа илрэлийг таслан зогсоож тухай бүрд нь хариуцлага тооцдог ажлыг шат шатанд нь хэрэгжүүлдэг болоход онцгой анхаарна.

4.2 Иргэний нийгмийн байгууллагын зүгээс тавих хяналтыг хүчтэй болгож аймгийн засаг даргын тамгын газар дээр нээлттэй утас ажиллуулна.

4.3 Аймагт хэрэгжиж байгаа болон хэрэгжих төсөл хөтөлбөр тендер шалгаруулалтыг ил тод нээлттэй байлгаж хяналт тавих үйл ажиллагаанд нь иргэний нийгмийн байгууллагуудаас оролцуулж ажиллана.

4.4 Аймгийн засаг даргын дэргэдэх хотын захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэд хөдөлмөрчдөд ил тод нээлттэй байлгаж хийсэн ажлын тайлан үр дүнг хэлэлцүүлж хэвшүүлнэ.

4.5 Төрийн архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх архивын тоо бүртгэл эрэлт хайлтын үйл ажиллагааг боловсронгуй болгох баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шийдвэрлүүлнэ.

4.6 Манай аймагтай хил залгаа орших ОХУ-н Туватай тогтоосон харилцаа холбоог улам бататган хөгжүүлж бүтээн байгуулалт соёл боловсрол спорт урлагийн чиглэлээр идэвхтэй хамтран ажиллана.

### **ТАВ. ДЭД БҮТЭЦ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ХАНГАХ ЗОРИЛТ**

Хөгжлийн хүрсэн түвшинг бататган дэд бүтэц үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн бүтцийг сайжруулж өсөлтийг хангана.

5.1 Сумын нутаг дэвсгэрт иргэдэд үйлчлэх цогц үйлчилгээний төвийг байгуулах ажлыг санаачлан аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж шийдвэрлүүлнэ. Багийн бүрэлдэхүүний ажиллах орчинг сайжруулснаар иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

5.2 Сумын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах төсөл боловсруулж гэр хорооллын доторх зам, цэвэр усны шугам, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ.

5.3 Улаангом сумд шинээр газар өмчлөн авсан иргэдийн цахилгаан хангамжийг шийдвэрлэхэд анхаарч шуурхай ажиллахад хяналт тавина.

5.4 Аялал жуулчлалын бүсийн дэд бүтцийг сайжруулж, Хархираа, Увс, Хяргас нуурыг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

5.5 Бүс нутгийн тодорхой хэрэглээг хангахуйц сүүн бүтээгдэхүүний үйлдвэр барьж байгуулахад анхаарч төсөл хэрэгжүүлэгч компанийн ажлыг дэмжинэ.

5.6 Улаангом сумд махны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр байгуулахад онцгой анхаарна.

5.7 Мах хүнсний ногоо сүү сүүн бүтээгдэхүүнийг хадгалах стандарт шаардлагыг хангасан агуулахын аж ахуйг байгуулах саналыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.

5.8 Улаангом сумд түүхий эд, техникийн төрөлжсөн зах байгуулахыг дэмжинэ.

5.9 Орчин цагийн барилгын хэрэглээний шаардлага, хэрэглээг хангасан олон төрлийн цонх үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

5.10 Чацаргана тарих төслүүдийг дэмжин ажиллана.

5.11 Баг дээрээ гурил гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх жижиг аж ахуйн нэгжүүдийг байгуулахад дэмжин ажиллана.

5.12 Жижиг дунд үйлдвэр, хоршоо, фермерийн аж ахуйг дэмжих зорилгоор хөгжлийн санг бий болгох ба техник тоног төхөөрөмжийг урт хугацаатай бага хүүтэй зээл түрээс, лизингээр олгох үйлчилгээний хэлбэрийг дэмжиж ажиллана.

5.13 Сум хоорондын зорчигч тээвэр шуудангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж сумдын зорчигч хүргэлт, шуудан, хэвлэл хүргэлтийн давтамжийг долоо хоногт 2-с доошгүй болгоно.

5.14 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцож аймгийн хөгжлийн хурдацийг тодорхойлон улсын дунджаас бууруулахгүй байх бодлого хэрэгжүүлж ажиллана.

5.15 Эдийн засгийн бүтцийг сайжруулах дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарыг эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.

5.16 Ашигт малтмалын боловсруулалтын түвшинг шат дараатай ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

5.17 Жижиг дунд үйлдвэрлэгчдэд зөвлөгөө өгөх, дэмжиж туслах инкубатор байгуулж үйл ажиллагааг нь хэвшүүлнэ.

5.18 Аймгийн 2012-2022 онд хөгжүүлэх урт хугацааны цогц бодлого боловсруулж аймгийн ИТХ-р хэлэлцүүлэн батлуулж мөрдөж ажиллана.

### **ЗУРГАА. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ЗОРИЛТ**

МАА-н үйлдвэрлэлд чанарын ахиц гаргаж, хүн ардаа экологийн цэвэр бүтээгдэхүүнээр бүрэн хангахад дэвшил гаргаж байгаль орчин хүний эрүүл мэндэд халтай технологийн үйл ажиллагаатай тууштай тэмцэнэ.

6.1 Эрчимжсэн болон хагас эрчимжсэн фермерийн загвар аж ахуйг шинээр байгуулах үүсгэл санаачлагыг дэмжиж, Улаангом суманд сүүний чиглэлийн Симменталь, Хар тарлан үүлдрийн үнээ бүхий загвар аж ахуй байгуулан ажиллах компанийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

6.2 Малын тэжээлийн үйлдвэрлэл, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс малын тэжээлийн цех байгуулахад онцгой анхаарч санал оруулна.

6.3 Арвин ашиг шимт нутгийн шилдэг омог болон цэвэр, эрлийз малын тоог нэмэгдүүлэх зорилгоор цөм сүрэг бүхий өрх айл, аж ахуйн нэгж байгууллагыг сум болгонд бий болгоход онцгойлон анхаарч, дэмжиж ажиллана.

6.4 Иргэд, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн оролцоотойгоор ундны усны худаг гаргахыг дэмжинэ.

6.5 Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон Хувьсгал” хөтөлбөрт хамрагдаж үйл ажиллагаа явуулж буй өрх бүрт төмс, хүнсний ногоо бүрээр дэмжлэг үзүүлдэг хэвшил тогтооход анхаарна.

6.6 Улаангом суманд хүлэмжийн аж ахуй шинээр байгуулахыг санаачлан ажиллана.

6.7 Алтны бага нөөцтэй шороон орд болон усны хагалбар, голын ай сав газар, ойн сан, байгалийн онцгой тогтоц бүхий газрууд, түүний хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, олборлохыг хориглох, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай арга технологиор уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг бүрэн зогсоох хөтөлбөр боловсруулна.